



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

MONTHLY BULLETIN OF STATISTICS

2018/7



www.nso.mn govisumber.nso.mn www.1212.mn



ГАРЧИГ

- I. Нийгмийн байдал.....
- II. Нийгмийн даатгал, халамж.....
- III. Эрүүл мэнд
- IV. Гэмт хэрэг
- V. Үнэ.....
- VI. Төсөв.....
- VII. Хөдөө аж ахуй
- VIII. Аж үйлдвэр
- IX. Цаг уур.....
- Хавсралт.....



Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал



I. Нийгмийн байдал


I.1 Ажил хайгч иргэд

Тайлант сарын эцэст Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэд 375, үүнээс ажил хайгч ажилгүй иргэдийн тоо 219 байгаагийн 114 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 47 буюу 17.7 хувиар, өмнөх сараас 41 буюу 15.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Долоодугаар сард Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт 77 ажлын байрны захиалга иржээ.

Тайлант сард 59 иргэн ажилд зуучлагдсаны 39 буюу 66.1 хувь нь эмэгтэйчүүд байна. Ажилд зуучлуулсан иргэд өмнөх оны мөн үеэс 28.3 хувиар нэмэгдсэн болно.

Зураг I.1. Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэн, жил бүрийн тайлант сарын эцэст



Ажил хайгч ажилгүй иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл 15-24 насны 55, 25-34 насны 81, 35-44 насны 44, 45-54 насны 31, 55 түүнээс дээш насны 8 иргэн байна.

I.2 Ердийн хөдөлгөөн


Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2018 оны эхний 7 сарын байдлаар 269 эх амаржиж, 270 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 73 буюу 37.2 хувиар, төрсөн хүүхдийн тоо 67 буюу 33.0 хувиар тус тус өссөн байна.

Нас баралт 46, бүртгүүлсэн гэр бүл 59, цуцалсан гэр бүл 13 байгаа нь өмнөх оны мөн үеэс цуцалсан гэр бүл 3 буюу 18.8 хувиар, нас баралт 20 буюу 30.3 хувиар буурч, бүртгүүлсэн гэр бүл 25 буюу 73.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд 5 хүүхэд үрчлэгдсэн. Шилжилт



хөдөлгөөний мэдээгээр 313 хүн шилжин ирж, 280 хүн шилжин явсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал шилжин ирэлт 18.1 хувиар, шилжин явалт 19.7 хувиар тус тус өсчээ.

Зураг 1.2.Төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 7 сарын байдлаар



II. Нийгмийн даатгал, халамж

II.1 Нийгмийн даатгал

2018 оны эхний 7 сарын байдлаар нийгмийн даатгалын сангийн орлого 5851.4 сая төгрөг, зарлага 6147.0 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс орлого 740.2 сая төгрөгөөр буюу 14.5 хувиар, зарлага 300.8 сая төгрөгөөр буюу 5.1 хувиар өссөн байна.

Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт 131.4 хувьтай, зарлагын гүйцэтгэл 99.6 хувьтай байна.

II.2 Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2018 оны эхний 7 сарын байдлаар 5558 хүнд 1182.3 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамж хүртэгсэд 1980 хүн буюу 55.3 хувиар нэмэгдэж, олгосон тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж 325.4 сая төгрөг буюу 38.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 2018 оны эхний 7 сарын байдлаар 1896 хүн хамруулж 683.1 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 974 хүн буюу 2.1 дахин олон, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 254.3 сая төгрөг буюу 59.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн үйлчилгээ хөнгөлөлт, тусламжид 2018 оны эхний 7 сарын байдлаар 3662 хүн хамруулж 499.2 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 1006 хүн буюу 37.9 хувиар, олгосон халамж үйлчилгээ, хөнгөлөлт, тусламж 71.1 сая төгрөг буюу 16.6 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.


II.3 Дундаж цалин

Аймгийн Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны 7 дугаар сарын мэдээгээр 203 байгууллагын 5210 даатгуулагч иргэн, үүнээс 554 нь сайн дурын даатгуулагч байна. Ажиллагсдын дундаж цалинг аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл



төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 11 аж ахуйн нэгж, байгууллагын 406 ажилтны дундаж цалин 663.6 мянган төгрөг, төсөвт 53 байгууллагын 1651 ажилтны дундаж цалин 652.0 мянган төгрөг, 2 Хувьцаат Компаний 663 ажилтны дундаж цалин 1114.2 мянган төгрөг, 119 ХХКомпаний 1814 ажилтны дундаж цалин 781.0 мянган төгрөг, бусад 18 аж ахуйн нэгж байгууллагын 152 ажилтны дундаж цалин 380.5 мянган төгрөг боллоо.

Зураг II.1. Нийгмийн даатгалын даатгуулагчийн тоо, 2018 оны эхний 7 сарын байдлаар




III. Эрүүл мэнд



Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2018 оны эхний 7 сарын байдлаар 288 эх амаржиж, 2017 оны мөн үетэй харьцуулахад 55 буюу 23.6 хувиар нэмэгдсэн байна. Амьд төрсөн хүүхэд 287 үүнээс 142 нь хүү, 145 нь охин байна. Өмнөх оны мөн үеэс амьд төрсөн хүүхэд 54 буюу 23.2 хувиар нэмэгдсэн байна.

0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл болон эхийн эндэгдэл бүртгэгдээгүй. 1-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл 1 бүртгэгдсэн байна.


Зураг III.1. Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, жил бүрийн эхний 7 сарын байдлаар





Халдварт өвчин эхний 7 сарын байдлаар 152 буюу 10000 хүн амд 91.2 хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 39 тохиолдлоор нэмэгдсэн.


Зураг III.2.Нас баралт, жил бүрийн эхний 7 сарын байдлаар



Он гарсаар давхардсан тоогоор 62956 хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 658 хүнээр буюу 1.1 хувиар, 2994 өвчтөн эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 132 хүнээр буюу 4.6 хувиар өссөн байна.

2018 оны эхний 7 сарын байдлаар түргэн тусламжийн дуудлага 3764, халдварт өвчин 152 бүртгэгдсэн байна.

Зураг III.3.Амьгүй төрсөн хүүхэд болон нялхасын эндэгдэл, жил бүрийн эхний 7 сарын байдлаар






IV. Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2018 оны эхний 7 сарын байдлаар 112 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 7 буюу 6.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг IV.1.Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн эхний 7 сарын байдлаар




Өмнөх оны мөн үеэс нийт гэмт хэргийн тоо өсөхөд хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг 28.3 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Илрээгүй гэмт хэрэг 52 байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.4 дахин өссөн. Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 52.0 болсон нь өмнөх оны мөн үеэс 3 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн улмаас 63 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеэс 10.0 хувиар буурсан байна.

Зураг IV.2.Гэмт хэргийн ангилал, жил бүрийн эхний 7 сарын байдлаар




Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2018 оны эхний 7 сарын байдлаар 418.2 сая төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 209.6 сая төг болж, өмнөх оны мөн үеэс учирсан хохирлын хэмжээ 2 дахин, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 36.2 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

2018 оны эхний 7 сарын байдлаар давхардсан тоогоор 418 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 6.6 хувиар өссөн байна.



Зураг IV.3. Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо жил бүрийн эхний 7 сарын байдлаар



V. Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ аймгийн хэмжээнд 2018 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 6.2 хувиар, 2017 оны жилийн эцсээс 4.4 хувиар, өмнөх сараас 0.6 хувиар өссөн байна.

Хүснэгт V.1. Хэрэглээний үнийн индекс, 2018 оны 7 дугаар сард, бүлгийн дүнгээр

Бараа үйлчилгээний бүлэг	2018. VII	2018. VII	2018. VII
	2017. VII	2017. XII	2018. VI
Ерөнхий индекс	106.2	104.4	100.6
Хүнсний бараа, ундаа, ус	108.1	110.6	101.7
Согтууруулах ундаа, тамхи	105.5	104.4	100.0
Хувцас, бөс бараа, гутал	101.1	100.4	100.0
Орон сууц, ус, цахилгаан, түлш	120.1	100.5	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	108.0	104.8	100.3
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	103.5	102.1	100.0
Тээвэр	108.9	107.2	101.5
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	99.9	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	103.7	105.3	100.0
Боловсролын үйлчилгээ	100.1	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	104.5	105.1	100.0
Бусад бараа, үйлчилгээ	101.8	101.0	100.0

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хорооны сарын мэдээ


**VI. Төсөв санхүү**

2018 оны эхний 7 сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 7821.3 сая төгрөг, гүйцэтгэлээр 8276.8 сая төгрөг болж 105.8 хувийн биелэлттэй байна.

Аймгийн төсвийн нийт зарлагын төлөвлөгөө 9645.1 сая төгрөг, гүйцэтгэлээр 8225.3 сая төгрөг болж 85.3 хувийн гүйцэтгэлтэй байна.


2018 оны эхний 7 сарын байдлаар авлагын үлдэгдэл 43.5 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 153.2 сая төгрөг байна.

Зураг VI.1. Орон нутгийн төсвийн орлого, зарлага, жил бүрийн эхний 7 сарын байдлаар, сая төгрөгөөр

**VII. Мал аж ахуй, газар тариалан**


Аймгийн хэмжээнд 2017 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 201476 хээлтэгч малын 141717 буюу 70.3 хувь нь төллөсөн байна. Төл бойжилт 84.9 хувьтай байна. 2018 оны эхний 7 сарын байдлаар 30652 толгой том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оны мөн үеэс 14.1 дахин их байна. Том малын зүй бус хорогдлын 20.8 хувь нь хээлтэгч мал байна.

Зураг VII.1. Төллөсөн хээлтэгч, жил бүрийн эхний 7 сарын байдлаар, толгойгоор






Зураг VII.2.Хорогдсон хээлтэгч, жил бүрийн эхний 7 сарын байдлаар, толгойгоор



2018 оны байдлаар аймгийн хэмжээнд нийт 40.2 га талбайд төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал тариалсан байна. Тариалсан талбайн мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулбал төмс 1.9 га талбайгаар буюу 11.3 хувиар, хүнсний ногоо 4.3 га талбайгаар буюу 24.7 хувиар буурч тэжээлийн ургамал 7.7 га талбайгаар буюу 2.8 дахин нэмэгдсэн байна.

Зураг VII.3.Тариалсан талбай, 2018 оны байдлаар, га

**VIII. Аж үйлдвэр**

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2018 оны эхний 7 сарын байдлаар 25.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.2 тэрбум төгрөг буюу 0.8 хувиар буурч, оны үнээр 27.6 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1.2 тэрбум төгрөг буюу 4.5 хувиар өслөө.

Шивээ-Овоо ХК нийт бүтээгдэхүүний 94.1 хувь буюу 23.9 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийт борлуулалтын 94.9 хувь буюу 26.2 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна.



Зураг VIII.1. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, салбараар, жил бүрийн эхний 7 сарын байдлаар, сая төгрөгөөр



IX. Цаг агаарын мэдээ 7 дугаар сард:

Хур тундас: 1, 2, 6-8, 11, 14, 15, 17-20, 23, 28, 29-ний өдөр бороо орж, нийт 69.5 мм тунадастай.


Салхи: Борооны өмнө салхи түр зуур ширүүсч 13 м/сек хүрсэн, бусад хугацаанд 4-9 м/сек салхитай байсан.

Агаарын температур: Нэгдүгээр арав хоногийн сүүл болон хоёрдугаар арав хоногийн эхээр шөнөдөө 8-13 градус дулаан, өдөртөө 22-27 градус дулаан, бусад хугацаанд шөнөдөө 13-18 градус дулаан, өдөртөө 27-32 градус дулаан байсан байна.


НАЙМДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

Агаарын температурын сарын дундаж нь 15-20 градус буюу уур амьсгалын дунджаас 1.0-1.5 градусаар дулаан байх төлөвтэй. Нэгдүгээр арав хоногийн дунд үе, хоёрдугаар арав хоногийн эхээр шөнөдөө 15-20 градус өдөртөө 32-37 градус хүрч халах төлөвтэй. Нэгдүгээр арав хоногийн эхэн, хоёр ба гуравдугаар арав хоногийн сүүлчээр сэрүүсч шөнөдөө 7-12 градус өдөртөө 20-25 градус дулаан байна. Бусад хугацаанд шөнөдөө 13-18 градус өдөртөө 26-31 градус дулаан байна.

Энэ сард уур амьсгалын дунджаас бага бороо орох төлөвтэй. Нэгдүгээр арав хоногийн эхээр бороо, нэг ба хоёрдугаар арав хоногийн дунд үе болон сүүлч, гуравдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар түр зуурын бороо орох төлөвтэй. Дуу цахилгаантай. Борооны өмнө салхи түр зуур ширүүснэ, ялангуяа нэгдүгээр арав хоногийн дунд үе болон сүүлч, хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн эцсээр зарим газраар түр зуур 14-16 м/с хүрч ширүүсэх төлөвтэй.



3 дугаар зураг. 8 дугаар сарын температурын урьдчилсан мэдээ



4 дүгээр зураг. 8 дугаар сарын хур тунадасны урьдчилсан мэдээ



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 I-VII	2018 I-VII	$\frac{2018 I - VII}{2017 I - VII} \%$
Нийгмийн статистик				
Амьд төрсөн хүүхэд	хүүхэд	233	287	123.2
Ажил хайгч ажилгүй иргэд, сарын эцэст	хүн	266	219	82.3
Халдварт өвчнөөр өвчлөгсөд	хүн	113	152	134.5
Бүртгэгдсэн гэмт хэрэг	хүн	105	112	106.7
Эдийн засгийн статистик				
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	8439.9	8276.8	98.1
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	7749.2	8225.3	106.1
Авлага	сая.төг	14.3	43.5	304.2
Өглөг	сая.төг	78.4	153.2	195.4
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	сая.төг	25603.7	25356.3	99.2
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт	сая.төг	26375.5	27593.5	104.5
Төллөсөн хээлтэгч	толгой	140897	141717	100.6
Гарсан төл	толгой	141710	142677	100.7
Хорогдсон төл	толгой	1370	21560	1573.7
Бойжсон төл	толгой	140340	121117	86.3
Том малын зүй бусын хорогдол	толгой	2170	30652	1412.5



I.1 АЖЛЫН БАЙРНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 7 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2017 I-VII	2018 I-VII	$\frac{2018 I - VII}{2017 I - VII} \%$
Ажил хайгч иргэд, сарын эцэст	417	375	89.9
Үүнээс: эмэгтэй	236	210	89.0
Ажил хайгч ажилгүй иргэд, сарын эцэст	266	219	82.3
Үүнээс: эмэгтэй	149	114	76.5
Ажлын байрны захиалга	47	77	163.8
Ажилд зуучлагдсан иргэд	46	59	128.3
Үүнээс: эмэгтэй	28	39	139.3

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээ

I.2 ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2017 I-VII	2018 I-VII	$\frac{2018 I - VII}{2017 I - VII} \%$
Амаржсан эх	196	269	137.2
Төрсөн хүүхэд	203	270	133.0
Үрчлэгдсэн хүүхэд	2	5	250.0
Бүртгүүлсэн гэр бүл	34	59	173.5
Цуцалсан гэр бүл	16	13	81.3
Нас баралт	66	46	69.7
Шилжин ирсэн	265	313	118.1
Шилжин явсан	234	280	119.7

Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээ

II.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Сангийн төрөл	2017 I-VII	2018 I-VII	$\frac{2018 I - VII}{2017 I - VII} \%$
НД-ын сангийн орлого, сая.төг	5 111 .2	5 851.4	114.5
НД-ын сангийн зарлага, сая.төг	5 846.2	6 147.0	105.1

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээ



II.2 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮН, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, жил бүрийн эхний 7 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I-VII		2018 I-VII		$\frac{2018 \text{ I} - \text{VII}}{2017 \text{ I} - \text{VII}} \%$	
	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн
Нийгмийн халамжийн сангийн дүн	3 578	856.9	5 558	1 182.3	155.3	138.0
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	922	428.8	1 896	683.1	205.6	159.3
Халамжийн тэтгэвэр	260	223.9	250	237.4	96.2	106.0
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	662	204.9	1 646	445.7	248.6	217.5
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт тусламж	2 656	428.1	3 662	499.2	137.9	116.6
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж, насны хишиг	722	138.5	1 350	146.4	187.0	105.7
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	91	17.3	71	16.5	78.0	95.4
Нийгмийн халамжийн үйлчилгээ	379	23.8	694	54.9	183.1	230.7
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт тусламж мөнгөн тусламж	250	80.1	294	108.1	117.6	135.0
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	5	5.8	5	5.8	100.0	100.0
Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж	1 209	162.6	1 248	167.5	103.2	103.0

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээ



III.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Үзүүлэлт	2017 I-VII	2018 I-VII	$\frac{2018 I - VII}{2017 I - VII} \%$
Төрсөн эх	233	288	123.6
Амьд төрсөн хүүхэд	233	287	123.2
Эрэгтэй	123	142	115.4
Эмэгтэй	110	145	131.8
Амьгүй төрсөн хүүхэд	1	1	100.0
Нийт нас баралт	51	36	70.6
Эмнэлгийн нас баралт	5	6	120.0
Хоног болоогүй нас баралт	5	2	40.0
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	0	-
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	3	1	33.3
Эмчлэгдсэн өвчтөн	2 862	2 994	104.6
Амбулаторийн үзлэг	62 298	62 956	101.1
Халдварт өвчин	113	152	134.5

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газрын мэдээ

IV.1 ЭРҮҮГИЙН БОЛОН ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН МЭДЭЭ , жил бүрийн эхний 7 сарын байдлаар, төрлөөр

Үзүүлэлт	2017 I-VII	2018 I-VII	$\frac{2018 I - VII}{2017 I - VII} \%$
Бүртгэгдсэн гэмт хэрэг	105	112	106.7
Хүний амьд явах эрхийн эсрэг, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	7	3	42.9
Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	46	59	128.3
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	32	35	109.4
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	3	3	100.0



Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал

Хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн	12	9	75.0
хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг			
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	0	0	-
Олон нийтийн аюулгүй байдал ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	4	1	25.0
Бусад гэмт хэрэг	1	2	200.0
Гэмт хэрэгт холбогдогсод	115	74	64.3
15 хүртэлх насны	2	1	50.0
16-34 насны	45	31	68.9
35 ба түүнээс дээш насны	68	42	61.8
Боловсрол – Дээд	20	13	65.0
Боловсрол - Тусгай дунд	6	8	133.3
Боловсрол – Бүрэн дунд	35	28	80.0
Боловсрол – Бүрэн бус дунд	30	16	53.3
Боловсрол – Бага	7	6	85.7
Боловсролгүй	17	3	17.6
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн	11	16	145.5
Ажилгүй иргэд үйлдсэн	51	44	86.3
Эмэгтэй хүн оролцсон	17	9	52.9
Хүүхэд оролцсон	13	5	38.5
Бүлгээр үйлдсэн	35	3	8.6
Согтуугаар үйлдсэн	41	44	107.3
Гэмт хэргийн гаралт, нөхцөл байдал	105	112	106.7
Гудамж талбай, олон нийтийн газар	27	33	122.2
Гэмт хэргийн улмаас нас барсан	8	4	50.0
Гэмт хэргийн улмаас гэмтсэн	70	63	90.0
Учирсан хохирол / сая.төг /	209.4	418.2	199.7
Нөхөн төлүүлсэн хохирол / сая.төг /	153.9	209.6	136.2

Эх үүсвэр: Цагдаагийн хэлтсийн мэдээ



VI.1 ТӨСВИЙН ОРЛОГО, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 7 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I-VII	2018 I-VII	$\frac{2018 I - VII}{2017 I - VII} \%$
Нийт орлого	8 439.9	8 276.8	98.1
Урсгал орлого	3 417.9	3 004.8	87.0
Татварын орлого	2 593.1	2 658.5	102.5
Татварын бус орлого	824.7	346.3	42.0
Тусламжийн орлого	5 022.0	5 272.0	105.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

VI.2 ТӨСВИЙН ЗАРЛАГА, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 7 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I-VII	2018 I-VII	$\frac{2018 I - VII}{2017 I - VII} \%$
Нийт зарлага	7 749.2	8 225 .3	106.1
Урсгал зардал	7 260.1	7 608.0	104.8
Хөрөнгийн зардал	489.1	617.3	126.2

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

VI.3 ТӨСВИЙН ӨГЛӨГ, АВЛАГЫН ҮЛДЭГДЭЛ, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 7 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I-VII	2018 I-VII	$\frac{2018 I - VII}{2017 I - VII} \%$
Авлага	14.3	43.5	304.2
Өглөг	78.4	153.2	195.4
Төсөвт байгууллагын тоо	49	49	100.0
Төсөвт байгууллагын ажиллагсад	783	783	100.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ



VII.1 МАЛ ТӨЛЛӨЛТ, эх малын төрлөөр, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Төрөл	2017 I-VII	2018 I-VII	$\frac{2018 I - VII}{2017 I - VII} \%$
Бүгд	140 897	141 717	100.6
Ингэ	120	139	115.8
Гүү	4 022	2 883	71.7
Үнээ	3 687	3 337	90.5
Эм хонь	69 113	71 775	103.9
Эм ямаа	63 955	63 583	99.4

VII.2 ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ сумдаар, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Сумд	2017 I-VII	2018 I-VII	$\frac{2018 I - VII}{2017 I - VII} \%$
Дүн	140 897	141 717	100.6
<u>Баянтал</u>	21 659	26 248	121.2
Сүмбэр	102 074	98 673	96.7
<u>Шивээговь</u>	17 164	16 796	97.9

VII.3 БОЙЖСОН ТӨЛ, төлийн төрлөөр, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Төрөл	2017 I-VII	2018 I-VII	$\frac{2018 I - VII}{2017 I - VII} \%$
Бүгд	140 340	121 117	86.3
Ботго	116	133	114.7
Унага	4 005	2 681	66.9
Тугал	3 659	3 128	85.5
Хурга	68 838	63 702	92.5
Ишиг	63 722	51 473	80.8

VII.4 БОЙЖСОН ТӨЛ, сумдаар, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Сумд	2017 I-VII	2018 I-VII	$\frac{2018 I - VII}{2017 I - VII} \%$
Дүн	140 340	121 117	86.3
<u>Баянтал</u>	21 789	25 036	114.9
Сүмбэр	101 333	78 910	77.9
<u>Шивээговь</u>	17 218	17 171	99.7



VII.5 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Төрөл	2017 I-VII	2018 I-VII	$\frac{2018 I - VII}{2017 I - VII} \%$
Бүгд	2 170	30 652	1 412.5
Тэмээ	3	7	233.3
Адуу	29	1 147	3 955.2
Үхэр	105	1 607	1 530.5
Хонь	803	11 286	1 400.2
Ямаа	1 230	16 605	1 350.0

VII.6 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Сумд	2017 I-VII	2018 I-VII	$\frac{2018 I - VII}{2017 I - VII} \%$
Дүн	2 170	30 652	1 412.5
<u>Баянтал</u>	260	2 227	856.5
Сүмбэр	1 827	27 948	1 529.7
<u>Шивээговь</u>	83	477	574.7

VII.7 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Төрөл	2017 I-VII	2018 I-VII	$\frac{2018 I - VII}{2017 I - VII} \%$
Бүгд	429	6 361	1 482.8
Тэмээ	0	1	-
Адуу	7	288	4 114.3
Үхэр	27	332	1 229.6
Хонь	208	2 128	1 023.1
Ямаа	187	3 612	1 931.6

VII.8 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Сумд	2017 I-VII	2018 I-VII	$\frac{2018 I - VII}{2017 I - VII} \%$
Дүн	429	6 361	1 482.8
<u>Баянтал</u>	31	358	1 154.8
Сүмбэр	377	5 878	1 559.2
<u>Шивээговь</u>	21	125	595.2



VIII.1 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт жил бүрийн эхний 7 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I-VII	2018 I-VII	$\frac{2018 I - VII}{2017 I - VII} \%$
Нийт	25 603.7	25 356.3	99.2
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	23 199.5	23 968.5	103.3
Боловсруулах аж үйлдвэр	1 104.5	70.0	6.3
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	1 299.8	1 317.8	101.4

VIII.2 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт, жил бүрийн эхний 7 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I-VII	2018 I-VII	$\frac{2018 I - VII}{2017 I - VII} \%$
Нийт	26 375.5	27 593.5	104.5
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	24 161.8	26 233.3	108.6
Боловсруулах аж үйлдвэр	997.0	53.7	5.4
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	1 216.7	1 306.5	107.4

VIII.3 Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үзүүлэлтүүд, Шивээ-Овоо ХК жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Үзүүлэлт	2017 I-VII	2018 I-VII	$\frac{2018 I - VII}{2017 I - VII} \%$
Нүүрс борлуулалт /үнийн дүнгээр, сая.төг/	24 161.8	26 233.3	108.6
Нүүрс гаргалт /үнийн дүнгээр, сая.төг/	23 199.5	23 968.5	103.3
Ажиллагсад	553	537	97.1



Е-майл хаяг:

Вэб хаяг:

Мэдээллийн сангийн хаяг:

Утас:

govisumber@nso.mn

govisumber.nso.mn

www.1212.mn

70543222, 70543017